



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2018.02.15 № 3/326  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ /НИЙСЛЭЛ/, ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
/ГАЗАР/-ИЙН ДАРГА НАРТ

**Чиглэл хүргүүлэх тухай**

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцож цагдаагийн алба хаасан хугацааг өсгөн нэмэгдүүлэхээр заасан.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2017 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 3/3059 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасан ажлын байр /албан тушаал/-ын жагсаалт”-ыг хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газраас дээрх албан тушаалын жагсаалтын “Улсын онц чухал объектын хамгаалалт, харуул”, “Замын хөдөлгөөн зохицуулах”, “Эргүүл”, “Жижүүрийн албанд” хэсэгт тус тус “гэрээт”, “Эргүүл”-ийн “эргүүлийн цагдаа” хэсэгт “сум дахь цагдаа” гэж нэмж оруулах санал ирүүлсэн байна.

Иймд дээрх хуулийн дагуу цагдаагийн алба хаагчийн алба хаасан хугацааг тооцоход “гэрээт”, “сум дахь цагдаа”-гаар алба хаасан хугацааг цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн нэмэгдүүлэн тооцож цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоож олгох нь зүйтэй.

Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны “Санал хүргүүлэх тухай” 5<sup>Б</sup>/930 албан бичгийг хавсарган хүргүүлэв.

Хувийг Мэдээллийн технологийн төвд.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ  
ГАЗРЫН ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,  
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

2018.02.13 № 50/930  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА  
Ц.ГАНЦЭЦЭГ ТАНАА

**Санал хүргүүлэх тухай**

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаад дахин талархал илэрхийлье.

Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2, Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт хамрагдах ажлын байр /албан тушаал/-ны жагсаалтад улсын онц чухал объектын хамгаалалт, замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албан тушаалыг оруулсан боловч "гэрээт" болон "сум дахь цагдаа" гэж зааж өгөөгүй нь тухайн ажлын байр /албан тушаал/-д ажиллаж байгаа болон ажиллаж байсан алба хаагчид дээрх хуулийн дагуу нэмэгдэл хоногийг тооцуулах боломжгүйд хүрч байна.

Иймд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/644 дүгээр албан бичгээр хүргүүлсэн жагсаалтын 2-5-д заагдсан албан тушаалд "... болон гэрээт ...", 4-ийн "эргүүлийн цагдаа" хэсэгт "сум дахь цагдаа" гэж тус тус нэмж оруулах саналыг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцан, шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ХЭЛТӨЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ж.БАЯСГАЛАН

0901107